

ЧОЙ.ЛУВСАНЖАВ, Г.ЛУВСАН НАР “ГЕРМАН ХЭЛ ӨӨРӨӨ СУРАХ БИЧИГ”-ТЭЭ ГЕРМАН, МОНГОЛ ХЭВШМЭЛ ХЭЛЛЭГИЙГ ХЭРХЭН ДҮЙЦҮҮЛСЭН НЬ

А. Цэрэнчулуун¹⁶⁹

Товч утга: Др. проф. Чой. Лувсанжав, Др. Гэндэн нар 1973 онд “Герман хэл өөрөө сурах бичиг” хэмээх номыг зохион хэвлүүлсэн нь одоо эрээд олдохгүй эрдэнэ, сураад олдохгүй сувд болжээ. “Герман хэл өөрөө сурах бичиг” ном зохион байгуулалт сайтай, авсаархан, герман хэл анхлан сурч байгаа хүнд ойлгомжтой, мөн герман хэлийг ямар нэг хэмжээнд суран хэрэглээ болгосон хүн ч гэсэн сөхөж харахад илүүдэхгүй нь лавтай. Орчуулах, хөрвүүлэх дасгалд монгол үлгэр, домог, хэвшмэл хэллэг, хэлц оруулсан нь номыг сонирхолтой болгожээ. Мөн номын оршилд хэл сурах хүнд зориулан үнэтэй сургамж өгсөн нь гадаад хэл сурч буй хэн бүхний мөрдөж явах зүйл ажээ.

Түлхүүр үг: хэвшмэл хэллэг, хэлц, дүйцүүлэл, ишлэх, иш татах, татал үг, хадмал, үгчилбэл, утгачилбал, хэлний орчин

Үндсэн агуулга

Номонд герман хэлний дүрмийг ойлгомжтой товчхон тайлбарлахын зэрэгцээ

хичээл нэг бүрд нижгээд хэлцийг орчуулах загвар болгон оруулж хэвшмэл хэллэгийг хэрхэн орчуулах, дүйцүүлэх талаар үлгэр өгчээ.

Мөн монгол ардын үлгэр домгийг орчуулан оруулсан нь ардын аман зохиолыг орчуулах сайхан жишээ болжээ.

Хэвшмэл хэллэг¹⁷⁰, хэлц¹⁷¹-ийн үг тус бүрийг монголоор оноон хадмал¹⁷²-даж өгсөн нь хэл сурч буй хүн герман үгүүлбэрийн бүтэц, үг нэг бүрийг хэрхэн хувиргадгийг мэдэж авахад нэн тустай болжээ. Дараа нь герман хэлцээ үгүүлбэрээр нь үгчлэн¹⁷³ орчуулаад, түүнийгээ монгол хүний сэтгэхүй, хэл ярианд нийцүүлэн утгачлан¹⁷⁴ буулгаж, улмаар монгол хэлэнд ийм утгатай ямар хэллэг байдгийг бодон олж, дүйцүүлэг¹⁷⁵ хийжээ. Тухайн цаг үед

¹⁶⁹ Орчуулагч, судлаач

¹⁷⁰ Цэцэн үг, мэргэн үг, сургаал үг зэрэг цөм хэвшмэл хэллэгийн төрөл

¹⁷¹ “**Өвөрмөц хэлц** гэдэг бол гагцхүү тухайн үндэстний хэлэнд дэх бүрэлдүүлсэн үгийн утга нь алдагдаад нэгэн нэгдмэл утга гаргах болсон тогтвортой **нийлэмж үг** юм. Хэдий тодорхой үзэгдлийн хувьд **өвөрмөц хэлц** нь нэгдүгээрт: хоёроос дээш үгээс бүтэх боловч утгын хувьд нэгэн бүхэл болж тухайлбал нэг л **ухагдахууныг заана**. Хоёрдугаарт: өвөрмөц хэлцийг бүрэлдүүлж байгаа **үгсийг ганц нэгээр нь салгаж болохгүй**. Гуравдугаарт: **түүнийг гадаад хэлнээ үгчлэн орчуулж болдоггүй** байна (Г. Аким Монгол өвөрмөц хэлцийн тайлбар толь)

¹⁷² Орчуулахдаа үг нэг бүрийг доор нь орчуулж тавихыг хадмал гэх бөгөөд энэ арга нь өгүүлбэрийн бүтцийг судлахад чухал ач холбогдолтой. Илтгэгч

¹⁷³ Орчуулгын энэ арга эх зохиолын хэллэгийг судлахад дөхөмтэй. Илтгэгч

¹⁷⁴ Орчуулгын энэ арга хөрвүүлгийг эх хэлээрээ унших хүнд ойлгомжтой болгодог. Илтгэгч

¹⁷⁵ Гадаад хэлнээ байгаа хэвшмэл хэллэг, хэлцийг тайлбарлах бус эх хэлнийхээ дүйцэх хэллэг, хэлцээр орлуулахыг дүйцүүлэх гэнэ. Илтгэгч

одоогийнхтой адил хэл сурах аудио, видео, ТВ, амьд хэл сурах **хэлний орчин** буй болоогүй байсан тул герман үгийг хэрхэн зөв дуудах талаар сурах бичигт онцгой анхаарч тайлбарлаж, зөвлөсөн байна.

Зөвхөн хэвшмэл хэллэгийг орчуулах жишээ оруулсан орчуулга хийж байгаа хүнд үлгэр авахуйц зүйл болжээ. Орчуулах гэдэг амар зүйл биш, тэгээд ч хэвшмэл хэллэг, өвөрмөц хэллэгийг орчуулах гэдэг бүр ч адармаатай, учир нь хэлцийг бүрэлдүүлбэр үг нэг бүрээр нь биш утгаар нь бүр нарийн ярьвал адил утгатай хэлцээр дүйцүүлдэг билээ.

Монгол улсад герман хэл сурах эрэлт, хэрэгцээ их байсан 1970-аад оны үед уг ном хэвлэгдэн гарсан нь цаг үеэ олсон бүтээл байлаа

Геологи, уул уурхай, хүнс, хөдөө аж ахуй, боловсролын салбарт хоёр улсын хамтын ажиллагаа эрчимтэй хөгжиж, манай улсын залуус БНАГУ-д их, дээд, тусгай мэргэжлийн сургуульд олноороо яван суралцаж, бас олон арван хөдөлмөрчид БНАГУ-д урт богино хугацаагаар үйлдвэрлэлийн дадлага хийж, герман орны хэл, соёлоос суралцаж, германы мэргэжилтэн нар ирж ажиллаж байсан, нэг үгээр хэлэхэд герман хэлний эрэлт, хэрэгцээ ид эрч хүчээ авч, монгол оронд герман хэл сурах хүсэл эрмэлзэл ид өрнөж, герман хэлний сурах бичгийн эрэл хайгуулд гарч байсан үе билээ.

Энэ ном герман хэл сурч, сургаж байгаа хүмүүст туйлын хэрэгтэй ном байсан төдийгүй, гадаад хэл суралцаж байгаа хэн бүхэнд туйлын сургамжтай, мөрдлөг болгууштай сургаал, сургамж агуулсан байна.

“Гадаад хэл нэг барьсан хүн амралт, чөлөө, томилолтын хугацаанд ч тавьж орхилгүй үзвэл л сурч чадна, ... сурахад тийм амархан амарчлуулах элэг барихад амттай хэл гэж байхгүй байх. Ямар ч харь хэл үзэх хүн эрхбиш эх хэлнийхээ зүй тогтоол, зөв найруулгаан сайн мэдэх их чухаг. Эх хэлээ сайн мэдэхэд, ардын аман зохиолыг их үзэх, сонсох, ардын аман зохиолыг их үзэх, сонсох, ардын амьд хэлээс сурах, монгол бичгийн сайхнаас сурах энэ бүгд цөм анхааралтай болой. Оролдоод явсан хүн баймгайдаан их газар хорооно. Уйгагүй хүн уул нүхэлмой“ хэмээн сургасан ч даяарчлалын эрин үед англи хийгээд бусад гадаад хэл сурах шаардлага эрэлт хэрэгцээ урд урдынхаас улам их болсон өнөө үед дээрх анхааруулгын ач холбогдол нэмэгдэж байгаа нь мэдээж.

Алив гадаад хэлийг сурахад анхаарах зүйлийн талаар хоёр эрдэмтэн маань

- Алив хэлийг сурах хүн төлөөгүй амархан сурах хэлийг хайх аваас тийм амарчлуулах хэл гэж үгүйг,
- Хэл сурах хүн уйгагүй, өдөр алгасахгүй оролдоод ард нь гарахын чухлыг,
- Ямар ч гадаад хэлийг сурахад эх хэлээ сайн мэдэхийн чухлыг,
- Эх хэлнийхээ арвин баялгаас сурахын тулд, ардын аман зохиолыг их үзэх, сонсох, ардын амьд хэлээс сурах, монгол бичгийн сайхнаас сурахын чухлыг сургажээ.

Номонд орсон хэвшмэл хэллэг хийгээд түүний хадмал, угчилсэн, утгачилсан орчуулга:

1. Татал үг

герман эх	Ende gut alles gut.
хадмал	төгсгөл, эцэс, шувтарга/ сайн/ бүгд, шувт, цөм/ сайн
үгчилбэл	төгсгөл сайн бүгд сайн
утгачилбал	Шувтарга нь сайн болбаас шувтдаан сайн.

Илтгэгчийн нэмэлт тодруулга:

герман толинд хийсэн тайлбар:	sagt man, wenn eine Sache eingutes Endegenommen hat
орчуулга:	Ямар нэгэн юмыг амжилттай төгсөхөд энэ хэлцийг хэлдэг.
Дүйцүүлэл:	Санасан хэрэг сэтгэлчлэн бүтлээ. Хэдий удаан хийсэн юм гэдэггүй, хэн хийсэн юм гэдэг. Амар сайхандаа жаргалаа.

2. Татал үг

герман эх	Aus den Augen aus dem Sinn.
хадмал	- аас ⁴ /нүд (олон)/ - аас ⁴ /сэтгэл санаа
үгчилбэл	Нүдэнд эс харагдвал мартчихдаг.
утгачилбал	хөндийрвөл мартчихдаг.

Илтгэгчийн нэмэлт тодруулга:

герман толинд хийсэн тайлбар:	Das, was man nicht mehr sieht, vergisst man; Wer abwesend ist, wird leicht vergessen
орчуулга:	үзэгдэхгүй байгаа юмаа хүн мартдаг, алга байгаа хүнийг амархан мартдаг.
Дүйцүүлэл:	Бие холдвол, сэтгэл холддог. Хараанаас гарвал, сэтгэлээс гардаг.

3. Татал үг

герман эх	Die Zeit heilt alle Wunde.
хадмал	цаг, зав/ эмнэх/ бүх/ шархнууд
үгчилбэл	цаг хугацаа бүх шархыг эмнэдэг. Цагийн урсгал мэсийн шархыг эдгээнэ.
утгачилбал	Өвчин анасан өдрөөс өвдөж байснаа мартдаг. Энэ үг нь ачитны ачийг ядрах цагтаа наана гээд хэргээ бүтмэгц ачитнаа мартдагийн үлгэрээс гаралтай гэжээ.

4. Татал үг

герман эх	Ein voller Bauch studiert nicht gern
хадмал	Нэг/ бүтэн/ гэдэс/ сурах/ үгүй/ дуртай
үгчилбэл	дүүрэн гэдэс сурах дүргүй
утгачилбал	Ухаан сүвийг тос бөглөдөг.

Илтгэгчийн нэмэлт тодруулга:

герман толинд хийсэн тайлбар:	Man sollte nicht zu viel essen, wenn man schwere geistige Arbeit verrichten muss
орчуулга:	Бүр ромчуудын үед цатгалан хүн сурах дүргүй (Plenus venter non studet libenter) хэмээдэг байжээ. Харин латин хэлээр "studere" гэдэг нь германы "studieren" -тэй адил сурах, судлах гэсэн үг биш харин ямар нэг юм “хийх, оролдох” гэсэн утгатай ажээ. Хоол идсний дараа хүн ноцоороод юм хийх дүргүй. Хоол идсний дараа сууж оюуны хөдөлмөр хийхэд үр дүн муутай байдаг, харин явж хөдлөх нь нэмэртэй байдаг болой.
Дүйцүүлэл:	Цатгалан хүн залхуу.

5. Татал үг

герман эх	Eigener Herd ist Goldes wert.
хадмал	өөрийн /голомт/ бол /алтан/ үнэтэй хувийн өргөө
үгчилбэл	өөрийн гэр алт мэт үнэтэй
утгачилбал	хар гэртээ хаан, бор гэртээ богд. Сиймхий ч гэсэн гэр минь, сэгсгэр ч гэсэн ээж минь

Илтгэгчийн нэмэлт тодруулга:

герман толинд хийсэн тайлбар:	Ein Herd, Kochherd oder Küchenherd , ist ein Gerät zum Kochen, Braten und Backen von Speisen, in seiner ursprünglichen Bedeutung die Feuer- bzw. Kochstelle eines Hauses oder Zeltens.
орчуулга:	Тогоо,(чанах тогоо, гал тогоо) цай чанах, хоол шарах, жигнэхэд зориулсан хэрэгсэл. Анхны утга нь гэр, майханд гал түлдэг газар буюу гал голомт ажээ. Галаа бадраадаг гэр орон, өөрийн амины өмч гэсэн утгаар ч хэлж болох талтай.
Дүйцүүлэл:	Өөрийн сүрэг өнгөтэй.

6. Татал үг

герман эх	Arbeit macht das Leben süß.
хадмал	ажил/хөдөлмөр/ хийдэг, болгодог/ аж төрөл/ амттай.

үгчилбэл	Ажил, аж төрлийг амттай болгодог.
утгачилбал	Ажил гэдэг аж төрөлд шим өгдөг

Илтгэгчийн нэмэлт тодруулга:

Дүйцүүлэл:	Ажил хийвэл ам тосолдог.
------------	--------------------------

6. Татал үг

герман эх	Eine Hand wäscht die andere.
хадмал	нэг/ гар/ угаадаг/ нөгөөгөө
үгчилбэл	нэг гар нь нөгөөгөө угаадаг
утгачилбал	Дэм дэмэндээ, дээс эрчиндээ. Нөхрийн тус бүтвэл өөрийн тус бүтнэ

Илтгэгчийн нэмэлт тодруулга:

герман толинд хийсэн тайлбар:	man hilft sich gegenseitig zum beiderseitigen Vorteil;
орчуулга:	Бие биенийхээ тусын тулд харилцан тусалдаг.
Дүйцүүлэл:	Хүн хүнийхээ хүчинд, загас усныхаа хүчинд.

7. Татал үг

герман эх	Irren ist menschlich
хадмал	эндэл /бол/хүнийх
үгчилбэл	эндэх нь эр хүний ёс (хүн будилж болдог. Будилах бол байдаг л зүйл)
утгачилбал	эндэх нь эр хүний ёс, эргэж засах нь хүний ёс. Эр нэг энддэг, эрэг нэг нурдаг.

Илтгэгчийн нэмэлт тодруулга:

герман толинд хийсэн тайлбар:	Jeder kann sich mal irren
орчуулга:	хүн бүхэн будилж болно.
Дүйцүүлэл:	Хүн будилж болно. Хүлэг бүдэрч болно.

8. Татал үг

герман эх	Hunger ist der beste Koch.
хадмал	өлсгөлөн/ бол/ овоо, сайн/ тогооч
үгчилбэл	Өлсөхөд хоол л бол сайхан
утгачилбал	Өлсөө хүнд үзэгдэгч бүхэн амттай. Өлсөхөд өл бугын эвэр зөөлөн цадахад цагаан хурганы сүүл хатуу.

Илтгэгчийн нэмэлт тодруулга:

герман толинд хийсэн тайлбар:	Wenn man Hunger hat, dann schmeckt jedes Essen
орчуулга:	өлссөн хүнд хоол бүхэн сайхан
Дүйцүүлэл:	өлссөн хүнд хоол бүхэн амттай.

9. Татал үг

герман эх	Erst mach dein Sach' dann lach'!
хадмал	эхлээд/ хий- /чиний/ үйл хэрэг/ дараа/ инээ!
үгчилбэл	Эхлээд үйл хэргээ хий, дараа нь инээ!
утгачилбал	Бадарчин баярлах нь орой нь дээр Бадарчин баярлах болоогүй.

10. Татал үг

герман эх	leicht gesagt, schwer getan.
хадмал	амархан, хөнгөн/ хэлсэн/ хүнд/ хийсэн
үгчилбэл	хэлсэн амархан хийсэн хэцүү.
утгачилбал	Хэлэхэд амар, хийхэд хэцүү.

11. Татал үг

герман эх	Morgen, morgen, nur nicht heute, sagen, alle faulen Leute.
хадмал	маргааш/ маргааш/ л биш/ өнөө/ хэлдэг/ бүх/ залхуу/ хүн.
үгчилбэл	Бүх залхуу хүэ өнөө биш маргааш маргааш хэмээн хэлдэг
утгачилбал	Залхуу хүний маргааш олон.

12. Татал үг

герман эх	Der Mensch ist ein Gewohnheitstier.
хадмал	Хүн /бол/ хэв ёстой/ адгуус (зуршилтай амьтан).
үгчилбэл	хүн хэмээх ёс мэдэх адгуус
утгачилбал	Ёс ёмбогор төр төмбөгөр. Ёсгүй хүн сүүлгүй нохой хоёр адил Хүн гэдэг зуршлаа тавьдаггүй амьтан.

13. Татал үг

герман эх	Jung gewohnt, alt getan.
хадмал	залуу/ заншсан/ хөгшин /хийсэн
үгчилбэл	Залуудаа заншсныг хөгшрөөд хийдэг.
утгачилбал	Өсөх насанд сурсан юм бүхэн өглөх насанд хэрэг болдог.

14. Татал үг

герман эх	Glück und Glas, wie leicht bricht das.
хадмал	аз жаргал/ ба/ шил/ яаж/ амар/ эвдрэх/энэ
үгчилбэл	Аз жаргал шил аяга амархан эвдэрдэг.
утгачилбал	Заяаны явдал замхрах нь зайрмагны толь шиг үтэрхэн

Илтгэгчийн нэмэлт тодруулга:

герман толинд хийсэн тайлбар:	Glück kann sehr schnell wieder vorbei sein
орчуулга:	аз жаргал амархан замхарч болно.
Дүйцүүлэл:	Амьдрал нэг хэвээрээ байдаггүй, аяга бүтнээрээ байдаггүй.

15. Татал үг

герман эх	Am Abend werden die Faulen fleißig.
хадмал	-д/ орой үдэш/ болдог/ залхуу/ ажилсаг
үгчилбэл	Залхуу хүн орой тийш ажилсаг болдог.
утгачилбал	Залхуу хүн ажлаа орой тийшээ хийдэг. Өдөр алдаж шөнө.

16. Татал үг

герман эх	Mache was, so kannst du was
хадмал	хий- /юу/ чадах/ чи/ юу
үгчилбэл	Чи юу чадахаа хий
утгачилбал	Чадах бүхнээ хий!

Илтгэгчийн нэмэлт тодруулга:

герман толинд хийсэн тайлбар:	Mache was, so kannst du was
орчуулга:	хий/ юм/, тэгээд/ чадна/ чи/ юу
Дүйцүүлэл:	Оролдвол нэгийг бүтээнэ, уралдвал ...

17. Татал үг

герман эх	Soviel Köpfe soviel Sinne.
хадмал	төдий чинээ/ толгой/ төдий чинээ/ ухаан сэтгэл
үгчилбэл	Төдий чинээн толгой байвал төдий чинээн ухаан бий.
утгачилбал	Хүн хүний санаа, гүзээ гүзээний булан ондоо.

18. Татал үг

герман эх	Durch Schaden wird man klug.
хадмал	-аар/зовлон/ болдог/.../ ухаантай

Орчуулгазүй - V

үгчилбэл	Зовлонгоор ухаантай болдог.
утгачилбал	Хал үзэж хашир суудаг.

19. Татал үг

герман эх	Wer einmal lügt, dem glaubt man nicht und wenn er auch die Wahrheit sagt.
хадмал	хэн/ нэг удаа/ хуура-/ түүнд/ итгэ/ үгүй/ ба/ хэрэв/ тэр/ бас/ үнэн/ хэлэх
үгчилбэл	Нэг удаа хуурвал үнэн үг хэлж ч байсан үнэмшдэггүй.
утгачилбал	Нэг л хуурлаа бол хамаг үнээн бардаг.

20. Татал үг

герман эх	Wo ein Wille ist, da ist auch ein Weg.
хадмал	хаана/ нэг/ хүсэл/ байна/ тэнд/ байна/ бас/ нэг/ зам
үгчилбэл	Хүсэл бий аваас хүрэх зам буй.
утгачилбал	санаж явбал бүтнэ, сажилж явбал хүрнэ.

Илтгэгчийн нэмэлт тодруулга:

герман толинд хийсэн тайлбар:	Wenn man etwas wirklich will, dann findet sich auch eine Lösung ; Miteinem starkenWillen kann man viel erreichen
орчуулга:	Үнэхээр хийхийг хүсвэл нэг шийдвэр олдог. Шантаршгүй зорилготой хүн их юманд хүрдэг.
Дүйцүүлэл:	Хийх хүн арга олдог, хийхгүй хүн шалтаг заадаг

21. Татал үг

герман эх	Wenn du noch keinen Vögel siehst, sollst du deine Pfeile nicht gehen lassen.
хадмал	хэрэв/ чи/ бас/ үгүйг/ шувууд/ үзэх/ хэрэгтэй/ чи/ чинийг/ сумнууд/ үгүй/ ява-/орхи
үгчилбэл	хэрэв чи шувуу эс үзвэл сумаа явуулах хэрэггүй.
утгачилбал	Шувуу үзэлгүй сумаа битгий үр. Ус үзэлгүй гутлаа битгий тайл. Уул үзэлгүй хормойгоо битгий шуу.

22. Татал үг

герман эх	Wenn der Arzt schlecht ist, ist der Tod nahe. wenn das Weib schlecht ist, ist die Armut nahe.
хадмал	хэрэв/ эмч/ муу/ бол/ байна/ үхэл/ ойр хэрэв/ эм/муу/ бол/байна бол ядуурал/ ойр
үгчилбэл	Хэрэв эмч муу бол үхэл ойр байна.

	эм муу бол ядуурал ойр байна
утгачилбал	Эмч муу болбаас үхэхэд амархан. Эм муу болбаас үгүйрэхэд амархан.

Илтгэгчийн нэмэлт тодруулга:

герман толинд хийсэн тайлбар:	“Weib” ist ursprünglich in gehobener Sprache der <u>Paar</u> -Begriff zum <u>Mann</u> .
орчуулга:	Вайб гэдэг үг анх эхнэр гэсэн утгатай, өргөмжилсөн үг байжээ.
Дүйцүүлэл:	Муу эмч хүн ардыг сүйрүүлнэ. Муу эхнэр өрх гэрээ сүйрүүлнэ.

23. Татал үг

герман эх	Die Katze lässt das Mäusen nicht.
хадмал	муур/ орхи-/ хулганабарих/ үгүй
үгчилбэл	муур хулгана үзвэл орхихгүй
утгачилбал	Бас сурсан юмыг сураар боож болохгүй. Чоно махнаас гарах ч болоогүй.

24. Татал үг

герман эх	Wer den Kern essen will, muss die Nuss knacken.
хадмал	хэн/ –ийг/ цөм/ идэх/ хүсэх/ ёстой/ –ийг/ самар/ цөм
үгчилбэл	цөмий идье гэвэл цөмөж ид
утгачилбал	Барж идэхээр мэрж ид! Удаан даамгай! (Мах идье гэвэл, малдаа яв!)

25. Татал үг

герман эх	Wo man keinen Hund hat, bellt das Schwein.
хадмал	хаана /хүн/ үгүйг/ нохой/ байна/ хуцах/ гахай
үгчилбэл	Нохойгүй газар гахай хуцна
утгачилбал	Нохойгүйд гахай хуцдаг. Бурхангүй газар бомбо галзуурах. Мах олдохгүй газар богтос ахлах

26. Татал үг

герман эх	Heute rot, morgen tot.
хадмал	өнөөдөр/ улаан/, маргааш/ үхэл
үгчилбэл	өнөө улаан маргааш үхэл.
утгачилбал	үхэл үүдгүй.

27. Татал үг

герман эх	Andere Länder, Andere Sitten.
хадмал	өөр/ улс/ өөр /сэтгэл санаа ухаан
үгчилбэл	газар болгонд санаа нь өөр
утгачилбал	Газар газрын ёс ондоо

28. Татал үг

герман эх	Wenn man hilft, dann bis zu Ende. wenn man salzt dann bis zum richtigem Geschmack.
хадмал	хэрэв хүн тусалж байна, дараа хүртэл төгсгөл. хэрэв хүн давсалж байна, дараа хүртэл зөв амт
уг монгол нь	Тус хийвэл дуустал, давс хийвэл уустал (Монгол цэцэн үг)

29. Татал үг

герман эх	Wenn man dem Teufel den kleinen Finger gibt, so nimmt er die ganze Hand.
хадмал	хэрэв/ хүн/ -д/ чөтгөр/ -ийг/ жижиг/хуруу/ өгөх//, авах/ тэр/ бүгдийг/ гар
үгчилбэл	Чөтгөрт чигчий хуруугаа өгвөл ав авсаар бүгдийг авчихна.
утгачилбал	Муу хүнд гэрээ бүү үзүүл, мухар үхэрт худаг бүү үзүүл.

Дүгнэлт

Монголын эрдэмтэн, судлаачдын дүгнэлтээс үзэхэд зүйр, цэцэн, онч мэргэн, сургаал үг зэрэг цөм хүн ардын яриандаа урсгалаар хэрэглэдэг **хэвшмэл хэллэгийн** төрөл ажээ.

Өвөрмөц хэлц нь цагийн урсгалд орон уг хэлц үүссэн тохиолдол мартагдан, үүссэн орчин нөхцөл үгүй болж, шинэ орчин буй болохын хэрээр утга шилжин, улмаар хийсвэрлэлд орох учир илэрхийлэх утга нь бүрэлдүүлбэр үг тус бүрийн утгатай нийлэхгүй болдог байна.

“... **Өвөрмөц хэлц** нь нэгдүгээрт: хоёроос дээш үгээс бүтэх боловч утгын хувьд нэгэн бүхэл болж тухайлбал нэг л ухагдахууныг заана. Хоёрдугаарт: өвөрмөц хэлцийг бүрэлдүүлж байгаа **үгсийг ганц нэгээр нь салгаж болохгүй**. Гуравдугаарт: **түүнийг гадаад хэлнээ үгчлэн орчуулж болдоггүй**”¹⁷⁶.

“**Хэлц үгийг голдуу утгачлан орчуулна, хааяа үгчилж болно, бас өвөрмөц хэлцийг өвөрмөц хэлцээр дүйлгэх, бас зарим бүдүүлэг хэллэг, этгээд хэллэгийг мөн тохирох үгээр нь орчуулах хэрэгтэй.**”¹⁷⁷“Өвөрмөц хэлц

¹⁷⁶Г. Аким Монгол өвөрмөц хэлцийн тайлбар толь

¹⁷⁷Чой.Лувсанжав Орос-Монгол өвөрмөц хэллэгийн толь

гэдэг бол утгын хувьд бүрдүүлж байгаа үг тус бүрийн нь цөм утга алдарч, нийлэн нэгдэж, нэгэн ухагдахуун, утга санаа илэрхийлсэн, тухайн ард түмний **сэтгэхүй, сэтгэлгээ** нэвт шингэсэн, аж ахуй, бодот амидрал, хэв ёс, зан заншил, шашин шүтлэг, үзэл бодол гэх зэргийн **гүн тусгал** болсон **тогтвортой нийлэмж үг юм**” (Д.Бадамдорж, 2006 оны 124-р тал) гэж тодорхойлжээ.

Орчуулагчид тохиолддог хамгийн адармаатай зүйлийн нэг бол хэвшмэл хэллэгийн нэгэн төрөл болох өвөрмөц хэлц юм. Өвөрмөц хэлцийг орчуулахад нэгд үг тус бүрийг сайн ойлгох, хоёрт өгүүлбэрийн бүтэц, гол ба туслах гишүүнийг ялгаж салган ойлгох, гуравт хэлц дотор утга, шилжсэн үг байгаа эсэхийг анзаарах, дөрөвт хэлц үүссэн нөхцөл байдлыг судлах, тавд монгол хэлэнд уг хэлцийг утгыг хэрхэн гаргавал ойлгомжтой болох уу гэдгийг бодолцох хэрэгтэй мэт санагдана.

Энэ номонд сургамжтай, санаж явууштай 29 хэвшмэл хэллэг оржээ. Орчуулахад хамгийн төвөгтэй зүйл бол хэлц билээ.

Хэвшмэл хэллэгийн хадмал, үгчилсэн, утгачилсан орчуулгыг зохиогчийн бичсэнээр оруулаад зарим хэлц үгэн дээр герман тайлбарыг ашиглан илтгэгч миний бие нэмэлт тайлбар хийн өөрийн санаа бодлоор нэмэлт тайлбар орууллаа.

Ашигласан номзүй

1. Чой. Лувсанжав, Г. Лувсан “Герман хэл өөрөө сурах бичиг” Улсын хэвлэлийн газар, Улаанбаатар 1975,
2. Монгол хэлний өвөрмөц хэлцийн толь Монсудар хэвлэлийн газар 2013 он
3. Die schönsten Redewendungen garant verlag GmbH Renningen 2008